



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 109.

Сант сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд галын аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, гарч буй гал түймрийн тоог бууруулах, гэр хорооллын айл өрхүүдэд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар үзлэг шалгалт зохион байгуулах, пийшин, зуух, яндангийн аюулгүй байдлын стандарт, норм, нормативыг мөрдүүлэх, галын аюулгүй ажиллагааны зааварчилгааг таниулах, олон нийтэд сурталчилах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Мөнх-Эрдэнэ

(Засаг даргын орлогч)

Гишүүдэд: Б.Золбаяр

(Хушаат багийн Засаг дарга)

Л.Сэлэнгэсайхан

(Ивэн багийн Засаг дарга)

А.Батдорж

(Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

С.Сайнхишиг

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

М.Оюунбат

(Цахилгаанчин)

Х.Баярсайхан

(Цахилгаанчин)

2.Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг 2 үе шаттай зохион байгуулж тайланг 5 дугаар сарын 1, 11 дүгээр сарын 20-ны дотор Онцгой байдлын газрын урьдчилан сэргийлэх тасгийн Ganchimeg.galtsog999@gmail.com цахим хаягаар хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч Засаг даргын орлогч (Б.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.



С.ШИЖИРБААТАР

d/disk 2023 on zahiramj

43151009

Боловсруулсан: *Утга агуу*
Хянасан: *Ч. Армаг*
Хувь: *2*
Огноо: *2024 01 18*